



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/145

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8 дахь заалт, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хоршоо хөгжүүлэх сангийн ажлын гүйцэтгэлийн явцад хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Ажлын хэсгийн дарга: Э.Бадамханд (Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн )

Гишүүд: О.Отгонтуяа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)  
Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)

Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)  
Н.Түвшин (Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

2.Ажлын гүйцэтгэлийн явцад тогтмол хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Э.Бадамханд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН